



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/154

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотой зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх ажилд зориулж сумдад хуваарилах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай

2. Дээрх зардлын 40,000,000 (Дөчин сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр  
сарын 05 өдрийн А/15.4/ захирамжийн  
1 дүгээр хавсралт

МАЛ АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАХ, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛ  
ХАЛДВАРГУЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	Сумын нэр	Малын тоо	Зүй бусаар хорогдсон малын тоо	Устгалын цэгийн тоо	Зарцуулах мөнгөн дүн / сая /
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс					
1	Улаан-Уул	221678	15612	6	4,0
2	Баянзүрх	307094	14455	3	4,0
3	Мөрөн	239909	11024	1	3,0
4	Арбулаг	410352	12323	4	3,0
5	Их-Уул	309362	6285	3	3,0
6	Түнэл	301355	6617	2	3,0
7	Тосонцэнгэл	336919	4879	1	3,0
8	Рашаант	237037	5157	2	3,0
9	Тариалан	253585	3497	3	3,0
10	Ренчинлхүмбэ	193384	2753	3	3,0
11	Алаг-Эрдэнэ	216149	1920	2	2,0
12	Эрдэнэбулган	102595	1326	1	2,0
13	Ханх	61744	787	1	1
14	Чандмань-Өндөр	61598	418	2	1
15	Цагааннуур	26225	264	2	1
16	Цагаан-Үүр	33071	110	1	1
Нийт		3312057	87427	37	40,0

оОо